



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнд
оролцох бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2.3.8 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэх буудлуудын болон агаарын навигацийн үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах, байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнд оролцох бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны А/214 дүгээр тушаалаар батлагдсан “Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах журам”-ыг мөрдөж ажиллахыг нийт бүрэлдэхүүн, нарийн бичгийн даргад тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны А/214 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс /Ж.Зулцэцэг/-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
А/15.. дугаар тушаалын хавсралт



Үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнд
оролцох бүрэлдэхүүн

1. Дэд дарга /Нисэх буудлуудын үйлчилгээ хариуцсан/
2. Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга
3. Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга
5. Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлага, дотоод хяналтын албаны дарга
6. Захиргааны хэлтсийн дарга
7. Нисэх буудлуудын бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтсийн дарга
8. Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер
9. Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын менежер
10. Холбоо, навигаци, ажиглалтын албаны дарга
11. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга
12. Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны дарга
13. Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны дарга
14. Нислэгийн журам боловсруулалтын албаны дарга
15. "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын захирал
16. "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудлын Аэродромын албаны дарга
17. Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга
18. Аюулгүй байдал, хамгаалалтын албаны дарга
19. Оношилгоо, хэмжил зүйн лабораторийн эрхлэгч
20. Мэдээллийн технологи, инновацийн албаны дарга
21. Сэргээн засах амралтын дарга
22. Нисэхийн сургалтын төвийн захирал
23. Худалдан авах ажиллагааны тасгийн дарга
24. Нисэхийн цаг уурын төвийн дарга
25. Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн дарга

---oOo---